

ТӨСӨЛ

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

20...оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар

ХОТ

**ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Зөрчлийн тухай хуулийн 11.17 дугаар зүйлийн 6 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.**Зөрчлийн тухай хуулийн 11.17 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн “, 6” гэснийг хассугай.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг 2025 оны ... дугаар сарын ...-ны өдөр баталсан Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

ТӨСӨЛ

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

20...оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

**УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БИРЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалтын “болгон” гэсний дараа, 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийн “үйл ажиллагааг” гэсний дараа тус тус “Хөгжлийн банк,” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2025 оны ... дугаар сарын ...-ны өдөр баталсан Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

ТӨСӨЛ

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

20...оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

**ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ  
ЗААЛТЫГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2025 оны ... дугаар сарын ...-ны өдөр баталсан Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

ТӨСӨЛ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20...оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

### ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.48 дахь заалтын “болон” гэсний дараа “Хөгжлийн банкны бусдаас авсан санхүүжилт,” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2025 оны ... дугаар сарын ...-ны өдөр баталсан Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

20...оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

**ТӨВ БАНК/МОНГОЛБАНК/-НЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Төв банк/Монголбанк/-ны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “хүрээнд” гэсний дараа “Хөгжлийн банкны” гэж, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “хянан шалгагч” гэсний дараа “Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль,” гэж, 28<sup>2</sup> дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Хадгаламжийн даатгалын корпорацын гүйцэтгэх захирал” гэсний дараа “, Хөгжлийн банкны гүйцэтгэх захирал” гэж тус тус нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Төв банк/Монголбанкны/-ны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “газраас” гэснийг “газар, Хөгжлийн банкнаас” гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг 2025 оны ... дугаар сарын ...-ны өдөр баталсан Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

ТӨСӨЛ

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

20...оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

**ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2 дахь хэсгийн “үйл ажиллагааг” гэсний дараа “Хөгжлийн банк” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2025 оны ... дугаар сарын ...-ны өдөр баталсан Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

20...оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

**ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 8 дугаар зүйлд дараах агуулгатай 8.4, 8.5 дахь хэсгийг тус тус нэмсүгэй.

**1/8 дугаар зүйлийн 8.4, 8.5 дахь хэсэг:**

“8.4.Хөгжлийн сангийн хөрөнгийг Хөгжлийн банк удирдах ба сангийн хөрөнгөөр энэ хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалтад заасан төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлнэ.

8.5.Хөгжлийн банк сангийн үйл ажиллагааны тайланг Эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2025 оны ... дугаар сарын ...-ны өдөр баталсан Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

ТӨСӨЛ

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

20...оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

**БАНКНЫ ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Банкны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсгийн “Төв банкны үнэт цаас,” гэсний дараа “Хөгжлийн банкны үнэт цаас,” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2025 оны ... дугаар сарын ...-ны өдөр баталсан Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20....оны ....дугаар  
сарын ....-ны өдөр

Улаанбаатар хот

**ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд дор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй:

**1/1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 66 дахь заалт:**

“6.66.Монгол Улсын Хөгжлийн банкны хянан шалгагч Зөрчлийн тухай хуулийн 11.17 дугаар зүйлд заасан зөрчил.”

**2 дугаар зүйл.**Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 6.19 дэх заалтын “11.17 дугаар зүйл” гэснийг хассугай.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг 2025 оны ... дугаар сарын ...-ны өдөр баталсан Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

ТӨСӨЛ

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

20...оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

**ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлд дараах агуулгатай 6.5.23 дахь заалтыг нэмсүгэй.

**1/6 дугаар зүйлийн 6.5.23 дахь заалт:**

“6.5.23.Монгол Улсын Хөгжлийн банк”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2025 оны ... дугаар сарын ...-ны өдөр баталсан Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

ТӨСӨЛ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20...оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар

хот

### ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** 2017 оны 02 дугаар сарын 10-ны өдөр баталсан Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2025 оны ... дугаар сарын ...-ны өдөр баталсан Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ